



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2017 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/124

Улаанбаатар хот


Хамтын хэлэлцээрийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 9 дүгээр зүйлийн 9.4, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А/371 дугаар тушаалын дагуу 2017-2018 оны хамтын хэлэлцээрийн заалтуудыг СЭМҮТ-ийн Удирдлагын зөвлөл, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээнд тусгаж, хэрэгжүүлэн ажиллахыг Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга, тэргүүлэгч гишүүд нарт үүрэг болгосугай.

2. Хамтын хэлэлцээр, хамтын гэрээнд тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэн ажиллахыг Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил, мэдээллийн технологи эрхэлсэн дэд захирал /О.Баатаржав/, Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Энхжаргал/ нарт үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ

000906